



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/09

Ховд

Эзэмшил газрын хэмжээ, талбай өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, 2016 оны 55 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Цамбагарав баг Галданбошигт 1 дүгээр гудамжны 101 а тоотод байрлах Отгонбаатарын Нэргүй /ПЭ71062202/-ийн худалдаа, үйлчилгээний зориулалттай 254.0 метр квадрат газрыг хаягийн мэдээллийн сангийн дагуу 323.0 метр квадрат болгон 10 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Жаргалан баг Залуус 1 дүгээр гудамжны 101 тоотод байрлах Майдаржавын Байгальцэдэв /ПЮ73120808/-ийн худалдаа, үйлчилгээний зориулалттай 383.0 метр квадрат газрыг кадастрын мэдээллийн сангийн зургийн дагуу 513.0 метр квадрат болгон 13 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

3. Эзэмшил газрын хэмжээ талбай өөрчлөгдөж байгаа иргэн, аж ахуй нэгжид газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

4. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ